

МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 172

Улаанбаатар
хот

Техникийн тооллого хийх
журам батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.14 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1.“Техникийн тооллого хийх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Улсын Их Хурлын сонгуулийн техникийн тооллогын хуудас”-ыг 2 дугаар хавсралтаар, “Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн техникийн тооллогын хуудсыг” 3 дугаар хавсралтаар, “Улсын Их Хурлын сонгуулийн техникийн тооллогын дүнгийн нэгтгэл”-ийг 4 дүгээр хавсралтаар, “Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн техникийн тооллогын дүнгийн нэгтгэл”-ийг 5 дугаар хавсралтаар, “Техникийн тооллого хийсэн тухай тэмдэглэл”-ийг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод болон техникийн тооллого хийгдэх санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч нарт, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

Ц.БОЛДСАЙХАН

ТЕХНИКИЙН ТООЛЛОГО ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.13-т заасны дагуу техникийн тооллого хийх санал авах байрыг сонгох, санал авах байранд техникийн тооллого хийх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Санал хураалт дууссаны дараа Сум, дүүргийн сонгуулийн хороо харъяа хэсгийн санал авах байруудаас санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар 50 хүртэл хувийг сонгож 24 цагийн дотор техникийн тооллогыг хийж дуусгана.

1.3. Техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгох болон техникийн тооллого хийх ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, хамтарсан нам, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагчид, сонгогчид, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.

1.4. Санал авах байрны ахлах зохион байгуулагчийн даалгаснаар аль нэг зохион байгуулагч нь техникийн тооллого хийсэн тухай тэмдэглэл хөтлөнө.

Хоёр. Техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгох, бэлтгэх

2.1. Сум, дүүргийн сонгуулийн хороо нь техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгохдоо харъяа санал авах байруудын дугаар тус бүрийг тэмдэглэсэн сугалааг бэлтгэж, ажиглагчдад нэг бүрчлэн харуулсны дараа тусгайлан бэлтгэсэн хайрцагт хийнэ.

2.2. Нам, эвсэл, хамтарсан нам, нэр дэвшигчдийн төлөөлөл болон ажиглагчид харилцан тохиролцож нэг төлөөллөө томилон тусгайлан бэлтгэсэн хайрцагнаас сугалуулж, техникийн тооллого хийгдэх санал авах байрыг сонгоно.

2.3. Сум, дүүргийн сонгуулийн хороо нь техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон болохыг тухайн санал авах байрны ахлах зохион байгуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

Гурав. Техникийн тооллого хийх

3.1. Техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон санал авах байрны ахлах зохион байгуулагч болон зохион байгуулагчид нь Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.6-д заасны дагуу санал хураалтын үр дүнгийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хороонд дамжуулсны дараа техникийн тооллогыг нэн даруй эхлүүлж, дараах дарааллын дагуу завсарлагагүйгээр, ил тод, нээлттэй зохион байгуулна.

3.1.1.Техникийн тооллогыг эхлүүлэхээс өмнө санал авах ажиллагаанд ашигласан санал тэмдэглэх зориулалт бүхий бүх үзгийг хураан авч, тусгайлсан сав, хайрцагт хийж битүүмжлэн лацдана.

3.1.2.Тухайн санал авах байранд ажиллаж буй мэдээллийн технологийн даамал нь санал авах, тоолох төхөөрөмжийг саналын хайрцагт лацадсан улаан лацны бүрэн, бүтэн байдлыг шалган, ажиглагчдад харуулж, тэдний хяналтан дор лацыг хөндөж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

3.1.3.Лацыг хөндөж тэмдэглэлд тусгуулсны дараа мэдээллийн технологийн даамал санал авах, тоолох төхөөрөмжийг саналын хайрцагаас салгаж авна.

3.1.4.Санал авах байрны зохион байгуулагчид нь саналын хайрцагаас гарсан саналын хуудсуудыг 25 ширхэг тус бүрээр нь тоолж багцлана.

3.1.5.Багц тус бүрийг дугаарлах бөгөөд тухайн багц дахь саналын хуудсыг мөн дугаарлана. Багцын дугаар болон саналын хуудасны дугаарыг нэг дор тэмдэглэнэ. /1-1, 1-2, ... 1-25; 2-1, 2-2, ... 2-25; гэх мэт/.

3.1.6.Санал авах байрны ахлах зохион байгуулагч саналын хайрцагаас гарсан нийт саналын хуудас /багцалсан/-ны тоо нь тухайн санал авах байранд санал өгсөн сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ.

3.1.7.Ахлах зохион байгуулагч багцалсан саналын хуудсыг дугаарласан дарааллын дагуу саналын хуудас нэг бүрийг дугаарын дарааллаар тоолон саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг ажиглагчдад ил тод /видео камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/-оор харуулан, нэр дэвшигч нэг бүрийн авсан санал тус бүрийг уншиж танилцуулна, /Хэрэв сонгууль зэрэг явагдаж байгаа тохиолдолд сонгууль тус бүрээр нь/.

3.1.8.Ахлах зохион байгуулагч нь саналын хуудсыг уншиж танилцуулахдаа сонгууль тус бүрээр нь түүнчлэн нэр дэвшигч бүрийн авсан саналыг санал тус бүрээр нь унших бөгөөд ахлах зохион байгуулагчийн томилсон хоёр зохион байгуулагч Улсын Их Хурлын болон Орон нутгийн хурлын техникийн тооллогын хуудаст нэр дэвшигчдийн авсан саналыг тус тусад нь тухай бүрт нь тэмдэглэнэ.

3.1.9.Нэр дэвшигчид өгсөн саналыг тоолохдоо саналын хуудас тус бүрээр нь тоолж, улмаар багц тус бүрээр дүнг нэгтгэн гаргах бөгөөд тухай бүрт нь техникийн тооллогын дүнгийн нэгтгэлд бүртгэнэ.

3.1.10.Саналын хуудсыг тоолж дууссаны дараа техникийн тооллогын нэгдсэн дүнг гаргаж энэ тухай ахлах зохион байгуулагч мэдээлнэ.

3.2.Тэмдэглэлд санал авах байрны ахлах зохион байгуулагч болон зохион байгуулагчид гарын үсэг зурна. Техникийн тооллогын үйл ажиллагаанд оролцсон ажиглагчдаар тэмдэглэлд гарын үсэг зуруулж болно.

3.3.Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг тэмдэглэлд хавсаргана.

3.4.Санал авах байрны ахлах зохион байгуулагч нь техникийн тооллого хийсэн тухай дүнг сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдээлэх бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус нэн даруй мэдээлнэ.

3.5.Санал авах байр нь техникийн тооллого хийсэн тухай тэмдэглэл, бусад холбогдох баримт бичгийг сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус нэн даруй хүлээлгэн өгнө.

Дөрөв. Хариуцлага

4.1.Сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

(Энэ журамд 2016 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 267 дугаар тогтоол, 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.)

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн дугаар хэсгийн санал авах байрны техникийн тооллогын хуудас

Багц №

Хуудас № ...

20... оны ... дугаар сарын ... өдөр

[illegible]

Тайлбар: 1. Нэг нүдэнд зөвхөн нэг саналыг ☒ гэж тэмдэглэнэ.

2. Тухайн саналын хуудас дээрх хүчинтэй саналын тоо нь мандатын тооноос хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн саналын хуудас дахь саналыг дахин нягтлан шалгана.

3. Нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын “Дун”-ийн нийлбэр нь “Саналын хуудас дээрх нийт саналын тоо”-ны нийлбэртэй тэнцүү байх бөгөөд зөрсөн тохиолдолд тухайн багц дахь нийт 25 саналын хуудсыг дахин нягтлан шалгана.

Техникийн тооллогын хуудаст тэмдэглэл хийж дүнг гаргасан зохион байгуулагч /...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

..... аймаг /нийслэл/-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дугаар тойргийн
санал авах байрны техникийн тооллогын хуудас /УИХ-ын сонгуулийн тойргийн хэсэг/

Багц №
Хуудас № ...

20... оны ... дугаар сарын ... өдөр

Нэр дэвшигчийн нэр	Саналын хуудасны тоо																									Дүн
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	
1	А																									
2	Б																									
3	В																									
4	Г																									
5	Д																									
6	Е																									
7	Ж																									
8	З																									
9	И																									
10	К																									
11																										
Саналын хуудсан дээрх саналын тоо																										

Тайлбар: 1. Нэг нүдэнд зөвхөн нэг саналыг ☒ гэж тэмдэглэнэ.

2. Тухайн саналын хуудас дээрх хүчинтэй саналын тоо нь мандатын тооноос хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн саналын хуудас дахь саналыг дахин нягтлан шалгана.

3. Нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын “Дүн”-ийн нийлбэр нь “Саналын хуудас дээрх нийт саналын тоо”-ны нийлбэртэй тэнцүү байх бөгөөд зөрсөн тохиолдолд тухайн багц дахь нийт 25 саналын хуудсыг дахин нягтлан шалгана.

Техникийн тооллогын хуудаст тэмдэглэл хийж дүнг гаргасан зохион байгуулагч /...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

**Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн дугаар хэсгийн санал авах байрны техникийн
тооллогын дүнгийн нэгтгэл**

	Нэр дэвшигчийн нэр	Техникийн тооллогын хуудасны буюу багцийн дугаар																										Дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	...																	
1	А																											
2	Б																											
3	В																											
4	Г																											
5	Д																											
6	Е																											
7	Ж																											
8	З																											
9	И																											
10	К																											
11	Л																											
12	М																											
13	Н																											
14	О																											
15	П																											
16																												
17																												
18																												
19																												
20																												

Тайлбар: Хөндлөн нүд болгонд нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог багц тус бүрээр бичнэ.

Ахлах зохион байгуулагч
Зохион байгуулагч:

/...../
/...../
/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

..... аймгийн /Нийслэл/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн ... дугаар тойргийн
санал авах байрны техникийн тооллогын дүнгийн нэгтгэл /УИХ-ын сонгуулийн ... тойргийн ... хэсэг/

	Нэр дэвшигчийн нэр	Техникийн тооллогын хуудасны буюу багцийн дугаар																									Дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	...																
1	А																										
2	Б																										
3	В																										
4	Г																										
5	Д																										
6	Е																										
7	Ж																										
8	З																										
9	И																										
10	К																										
11	Л																										
12	М																										
13	Н																										
14	О																										
15	П																										
16																											
17																											
18																											
19																											
20																											

Тайлбар: Хөндлөн нүд болгонд нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог багц тус бүрээр бичнэ.

Ахлах зохион байгуулагч
Зохион байгуулагч:

/...../
/...../
/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ДУГААР ТОЙРГИЙН ДУГААР
ХЭСГИЙН САНАЛ АВАХ БАЙРАНД ТЕХНИКИЙН ТООЛЛОГО
ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

/..... аймаг/нийслэл/-ийн ИТХ-ын сонгуулийн
..... дугаар тойрог/

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

1.

..
..... сонгуулийн
санал авах ажиллагаа цагт дууссаны дараа техникийн тооллого
хийгдэхээр сонгогдсон тул тус санал авах байранд техникийн тооллогыг цаг
..... минутад эхлэв.

2. Техникийн тооллогын ажиллагааг ... хэсгийн санал авах байрны ахлах
зохион байгуулагч удирдаж, зохион байгуулагч
.....,
....., мэдээллийн
технологийн даамал нар оролцож гүйцэтгэв.

3. Нам, эвсэл, нэр дэвшигчдийн ажиглагчид болон сонгогчдын төлөөлөл:

1.
2.
3.
4. ...

нар оролцов.

5. Зохион байгуулагчид болон ажиглагчдын хяналтан дор, мэдээллийн
технологийн даамал ... хэсгийн санал авах байранд ашигласан санал тоолох
төхөөрөмжийн лацыг хөндөж, саналын хайрцагнаас санал тоолох төхөөрөмжийг
салгаж авав.

6. Саналын хайрцагнаас гаргаж авсан саналын хуудсуудыг тоолж, 25
ширхэгээр багцлан дугаарласан бөгөөд нийт багц, ширхэг саналын
хуудас байв.

7. Ахлах зохион байгуулагч саналын хайрцагнаас гарсан нийт саналын
хуудасны тоо, санал өгсөн сонгогчийн тоотой тохирч байгаа эсэхийг танилцуулав.

8. - хэсгийн санал авах байранд санал өгсөн сонгогчдийн тоо
- Санал тоолох төхөөрөмжөөс гарсан саналын хуудасны тоо

9. Санал өгсөн сонгогчдын тоо нь саналын хайрцагнаас гарсан саналын
хуудасны тоотой тохирч буй эсэх

.....
.....
..
.....
..

10. Ахлах зохион байгуулагч нь саналын хуудас тус бүрт
тэмдэглэсэн санал бүрийг сонгууль тус бүрээр, түүнчлэн нэр дэвшигч тус бүрээр
уншиж, ажиглагчдад ил тод /видео камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/-оор
харуулсан ба Улсын Их Хурлын сонгуулийн техникийн тооллогын хуудасны
тэмдэглэгээг зохион байгуулагч, Орон нутгийн хурлын
сонгуулийн техникийн тооллогын хуудасны тэмдэглэгээг зохион байгуулагч
..... нар тухай бүрт нь тус тус тэмдэглэв.

11. Техникийн тооллого дууссаны дараа нэгдсэн дүнг гаргаж нийтэд
танилцуулав.

10.1. Техникийн тооллогоор Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч:

1. /..... санал/
2. /..... санал/
3. ...

10.2. Техникийн тооллогоор орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын сонгуульд нэр дэвшигч:

1. /..... санал/
2. /..... санал/
3. ...

12. Техникийн тооллогыг ил тод, тасралтгүй явуулж, өдрийн цаг
минутад дуусгаж, мэдээлэв.

13. Саналын хуудсыг битүүмжлэх уутанд хийж сонгуулийн бусад баримт
бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлэхээр болов.

14. Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг хавсаргав.

Техникийн тооллого хийсэн:

Ахлах зохион байгуулагч

/ /

Зохион байгуулагчид:

/ /

Тэмдэг

/ /

/ /

/ /

/ /

/ /

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

..... аймаг /нийслэл/-ийн сум /дүүрэг/-ын
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дугаар тойргийн санал авах байрны
техникийн тооллогын хуудас

Багц №

Хуудас № ...

20... оны ... дугаар сарын ... өдөр

Хуудас №...		Саналын хуудасны тоо																									Есөн саян дугаар сарын ... өдөр									
	Нэр дэвшигчийн нэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	Дүн									
1	А																																			
2	Б																																			
3	В																																			
4	Г																																			
5	Д																																			
6	Е																																			
7	Ж																																			
8	З																																			
...																																				
Саналын хуудсан дээрх саналын тоо																																				

Тайлбар: 1. Нэг нүдэнд зөвхөн нэг саналыг ☒ гэж тэмдэглэнэ.

2. Тухайн саналын хуудас дээрх хүчинтэй саналын тоо нь мандатын тооноос хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн саналын хуудас дахь саналыг дахин нягтлан шалгана.

3. Нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын “**Дүн**”-ийн нийлбэр нь “**Саналын хуудас дээрх нийт саналын тоо**”-ны нийлбэртэй тэнцүү байх бөгөөд зөрсөн тохиолдолд тухайн багц дахь нийт 25 саналын хуудсыг дахин нягтлан шалгана.

Техникийн тооллогын хуудаст тэмдэглэл хийж дүнг гаргасан зохион байгуулагч /...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

..... аймаг /нийслэл/-ийн сум /дүүрэг/-ын
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дугаар тойргийн санал авах байрны
техникийн тооллогын дүнгийн нэгтгэл

	Нэр дэвшигчийн нэр	Техникийн тооллогын хуудасны буюу багцийн дугаар																									Дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	...																
1	А																										
2	Б																										
3	В																										
4	Г																										
5	Д																										
6	Е																										
7	Ж																										
8	З																										
9	И																										
10	К																										
...																											

Тайлбар: Хөндлөн нүд болгонд нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог багц тус бүрээр бичнэ.

Ахлах зохион байгуулагч
Зохион байгуулагч:

/...../
/...../
/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

**..... АЙМАГ /НИЙСЛЭЛ/-ИЙН СУМ /ДҮҮРЭГ/-ЫН
ИТХ-ЫН СОНГУУЛИЙН ДУГААР ТОЙРГИЙН ДУГААР ХЭСГИЙН
САНАЛ АВАХ БАЙРАНД ТЕХНИКИЙН ТООЛЛОГО ХИЙСЭН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ**

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

.....
..... сонгуулийн
санал авах ажиллагаа цагт дууссаны дараа техникийн тооллого
хийгдэхээр сонгогдсон тул тус санал авах байранд техникийн тооллогыг цаг
..... минутад эхлүүлэв.

Техникийн тооллогын ажиллагааг санал авах байрны ахлах зохион
байгуулагч удирдаж, зохион байгуулагч,
.....,
....., мэдээллийн технологийн даамал
..... нар оролцож гүйцэтгэв.

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн ажиглагчид болон сонгогчдын төлөөлөл:

1.
1.
2. нар оролцов.

Зохион байгуулагчид болон ажиглагчдын хяналтан дор, мэдээллийн
технологийн даамал дугаар хэсгийн санал авах байранд ашигласан санал
тоолох төхөөрөмжийн лацыг хөндөж, саналын хайрцагнаас санал тоолох
төхөөрөмжийг салгаж авав.

Саналын хайрцагнаас гаргаж авсан саналын хуудсуудыг тоолж, 25
ширхэгээр багцлан дугаарласан бөгөөд нийт багц, ширхэг саналын
хуудас байв.

Ахлах зохион байгуулагч саналын хайрцагнаас гарсан нийт саналын
хуудасны тоо, санал өгсөн сонгогчийн тоотой тохирч байгаа эсэхийг танилцуулав.

- Санал авах байранд санал өгсөн сонгогчдийн тоо
- Санал тоолох төхөөрөмжөөс гарсан саналын хуудасны тоо

Санал өгсөн сонгогчдын тоо нь саналын хайрцагнаас гарсан саналын
хуудасны тоотой тохирч /тохирохгүй/ байв. /доогуур нь зурж тэмдэглэх/
Тохироогүй тохиолдолд шалтгааныг олж тогтоон энэ тухай тайлбарыг бичих:

.....
..
.....
..
.....
..

Ахлах зохион байгуулагч нь саналын хуудас тус бүрт тэмдэглэсэн санал бүрийг нэр дэвшигч тус бүрээр уншиж, ажиглагчдад ил тод /видео камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/-оор харуулсан ба Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн техникийн тооллогын хуудасны тэмдэглэгээг зохион байгуулагч тооллогын хүснэгтэд тэмдэглэв.

Техникийн тооллого дууссаны дараа техникийн тооллогын дүнгийн нэгтгэлийг гаргаж санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнтэй тулган нийтэд танилцуулав.

Техникийн тооллогоор орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн авсан санал:

1. /..... санал/
2. /..... санал/
3. /..... санал/
-

Техникийн тооллогыг ил тод, тасралтгүй явуулж, өдрийн цаг минутад дуусгаж, уг тооллогын үеэр байлцсан хүмүүст мэдээлэв.

Тооллого явуулж дууссаны дараа саналын хуудсуудыг битүүмжлэн уутанд хийж сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлэхээр болов.

Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг хавсаргав.

Техникийн тооллого хийсэн:

Ахлах зохион байгуулагч

/ /

Зохион байгуулагчид:

Тэмдэг

/ /
/ /
/ /
/ /
/ /
/ /

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дугаар хэсгийн санал авах байрны техникийн тооллогын хуудас

Багц №
Хуудас № ...
сарын ... өдөр

20... оны ... дугаар

	Саналын хуудасны тоо Нэр дэвшигчийн нэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	<u>Дүн</u>
1	А																										
2	Б																										
3	В																										
4																											
<u>Саналын хуудсан дээрх нийт саналын тоо</u>																											

Тайлбар: 1. Нэг нүдэнд зөвхөн нэг саналыг ☒ гэж тэмдэглэнэ.

2. Тухайн саналын хуудас дээрх хүчинтэй саналын тоо нь мандатын тооноос хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд тухайн саналын хуудас дахь саналыг дахин нягтлан шалгана.

3. Нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын “Дүн”-ийн нийлбэр нь “**Саналын хуудас дээрх нийт саналын тоо**”-ны нийлбэртэй тэнцүү байх бөгөөд зөрсөн тохиолдолд тухайн багц дахь нийт 25 саналын хуудсыг дахин нягтлан шалгана.

Ахлах зохион байгуулагч
Зохион байгуулагч:

/...../
/...../
/...../
/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дугаар хэсгийн санал авах байрны техникийн
тооллогын дүнгийн нэгтгэл**

	Нэр дэвшигчийн нэр	Техникийн тооллогын хуудасны буюу багцийн дугаар																										Дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	...																	
1	А																											
2	Б																											
3	В																											
4																												

Тайлбар: Хөндлөн нүд болгонд нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог багц тус бүрээр бичнэ.

Ахлах зохион байгуулагч
Зохион байгуулагч:

/...../
/...../
/...../

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн
172 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ... ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
.... ДУГААР ХЭСГИЙН САНАЛ АВАХ БАЙРАНД ТЕХНИКИЙН ТООЛЛОГО
ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

.....

..

..... сонгуулийн санал авах
ажиллагаа цагт дууссаны дараа техникийн тооллого хийгдэхээр
сонгогдсон тул тус санал авах байранд техникийн тооллогыг цаг
минутаад эхлүүлэв.

Техникийн тооллогын ажиллагааг санал авах байрны ахлах зохион
байгуулагч удирдаж, зохион байгуулагч,
....., , , ,
....., мэдээллийн технологийн даамал нар
оролцож гүйцэтгэв.

Нам, хамтарсан нам, нэр дэвшигчдийн ажиглагчид болон сонгогчдын
төлөөлөл:

1.

2.

3. нар оролцов.

Зохион байгуулагчид болон ажиглагчдын хяналтан дор, мэдээллийн
технологийн даамал дугаар хэсгийн санал авах байранд ашигласан санал
тоолох төхөөрөмжийн лацыг хөндөж, саналын хайрцагнаас санал тоолох
төхөөрөмжийг салгаж авав.

Саналын хайрцагнаас гаргаж авсан саналын хуудсуудыг тоолж, 25
ширхэгээр багцлан дугаарласан бөгөөд нийт багц, ширхэг саналын
хуудас байв.

Ахлах зохион байгуулагч саналын хайрцагнаас гарсан нийт саналын
хуудасны тоо, санал өгсөн сонгогчийн тоотой тохирч байгаа эсэхийг танилцуулав.

- Санал авах байранд санал өгсөн сонгогчдийн тоо

- Санал тоолох төхөөрөмжөөс гарсан саналын хуудасны тоо

Санал өгсөн сонгогчдын тоо нь саналын хайрцагнаас гарсан саналын
хуудасны тоотой тохирч /тохирохгүй/ байв. /доогуур нь зурж тэмдэглэх/
Тохироогүй тохиолдолд шалтгааныг олж тогтоон энэ тухай тайлбарыг бичих:

.....

..

.....

..

.....

..

Ахлах зохион байгуулагч нь саналын хуудас тус бүрт
тэмдэглэсэн санал бүрийг нэр дэвшигч тус бүрээр уншиж, ажиглагчдад ил тод
/видео камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/-оор харуулсан ба Ерөнхийлөгчийн

сонгуулийн техникийн тооллогын хуудасны тэмдэглэгээг зохион байгуулагч
..... тооллогын хүснэгтэд тэмдэглэв.

Техникийн тооллого дууссаны дараа техникийн тооллогын дүнгийн нэгтгэлийг
гаргаж санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнтэй тулган нийтэд танилцуулав.

Техникийн тооллогоор Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн авсан
санал:

1. /..... санал/
2. /..... санал/
3. /..... санал/
-

Техникийн тооллогыг ил тод, тасралтгүй явуулж, өдрийн
..... цаг минутад дуусгаж, уг тооллогын үеэр байлцсан хүмүүст мэдээлэв.

Тооллого явуулж дууссаны дараа саналын хуудсуудыг битүүмжлэл бүхий
уутанд хийж сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн
хороонд хүргүүлэхээр болов.

Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг хавсаргав.

Техникийн тооллого хийсэн:

Ахлах зохион байгуулагч	/
Зохион байгуулагчид:	/
Тэмдэг	/
	/
	/
	/